



МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2002 оны 6 сарын 25 өдөр

Дугаар 184

Улаанбаатар хот

Гадаадад суралцуулах тухай

"Өндөр хөгжилтэй орнуудад суралцагчдын асуудлаар санал, дүгнэлт гаргах комисс"-ын 2002 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн хурлын тэмдэглэл, Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Санхүү, Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дугаар хамтарсан тушаалаар баталсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын 2,6-г үндэслэн ТУШААХ НЬ:

1. Дамбажав овогтой Ганболдыг ОХУ-ын Гадаад Хэргийн яамны дэргэдэх Дипломатын академийн аспирантурт 2 жилийн хугацаагаар, Моломжамц овогтой Бат-Өлзийг Москвагийн Олон Улсын Харилцааны Дээд сургуулийн магистрантурт 1 жилийн хугацаагаар тус тус 2002-2003 оны хичээлийн жилээс суралцуулсугай.
2. Дорж овогтой Ганбат, Жаргай овогтой Батсүх нарыг ОХУ-ын Дотоод Явдлын яамны Улсын гал түймэртэй тэмцэх албаны академид тус тус 2 жилийн хугацаагаар 2002-2003 оны хичээлийн жилээс суралцуулсугай.
3. Ванжилдорж овогтой Лувсанчүлтэмийг Австрали улсын Өмнөд Австралийн Их сургуулийн магистрантурт худалдааны чиглэлээр 2 жилийн хугацаагаар, Дашдорж овогтой Мөрөнг ОХУ-ын Дотоод Явдлын яамны Удирдлагын академийн аспирантурт эрх зүйн чиглэлээр 3 жилийн хугацаагаар, Энхтүвшин овогтой Болормааг АНУ-ын Арканзасын Их сургуульд 1 жилийн хугацаагаар, Сандалхан овогтой Бакытжаныг Англи улсын Оксфордын Их сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр 1 жилийн хугацаагаар, Тайванхүү овогтой Алтангэрэлийг ХБНГУ-ын Ханноверийн Их сургуулийн магистрантурт эрх зүйн чиглэлээр 1,5 жилийн хугацаагаар тус тус 2002-2003 оны хичээлийн жилээс суралцуулсугай.
4. Украин улсын Харьков хотын Их сургуулийн аспирантурт суралцаж буй Намхай овогтой Тунгалагийн эрдэм шинжилгээний ажлын хамгаалалтын зардлыг зээлээр олгосугай.
5. Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Санхүү, Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дугаар хамтарсан тушаалаар

баталсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Б.Ганбат/, энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын бодлого, зохицуулалтын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.

6. "Гадаадад суралцуулах тухай" Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2001 оны 390 дугаар тушаалыг хүчингүй болгосугай.



*Tsam...*  
А. ЦАНЖИД